

НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ГАРАХ ТООН ҮЗҮҮЛЭЛТ

2025 оны 01 дүгээр сарын 03

Улаанбаатар хот

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Түвшин /тоо хэмжээ						Нийт	Тайлбар
			2019	2020	2021	2022	2023	2024		
1	Биеийн тамир, спортын хамтлаг	Хамтлагийн тоо өсөлт	795	795	797	805	808	816	816	Нийслэлийн Засаг даргын 2006 оны А/164 дүгээр захирамжийн хүрээнд нийслэлийн хэмжээнд 816 биеийн тамир, спортын хамтлаг байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.
2	Магадлан итгэмжлэлд хамрагдсан байгууллага	Магадлан итгэмжлэгдсэн спорт клуб /өссөн дүнгээр/	11	11	13	13	13	28	28	Спорт клубүүд магадлан итгэмжлэлд сайн дурын үндсэн дээр хамрагдах, магадлан итгэмжлэгдсэн клубүүдэд хичээллэж буй иргэд эрүүл мэндийн даатгалын сангаас урамшуулал авах эрх зүйн орчин 2019 оноос үйлчилж 2021 оноос түр зогссон бөгөөд нийслэлийн хэмжээнд 28 спорт клуб магадлан итгэмжлэлд хамрагдсан байна.
3	Нийслэлийн иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн биеийн тамирын үйл ажиллагаанд оролцсон иргэд	Биеийн тамирын үйл ажиллагаанд оролцогчдын тоо /өссөн дүнгээр/	756,451	58,310	635,486	1,170,073	873,313	888,500	4,382,133	2019-2024 оны хооронд зохион байгуулсан нийтийн биеийн тамирын томоохон арга хэмжээнд давхардсан тоогоор 4,382,133 иргэн хамрагдсан байна.
4	Өвлийн арга хэмжээнд оролцогчдын тоо	Арга хэмжээнд оролцогчдын тоо /өссөн дүнгээр/	400,000	0	287,800	416,572	425,100	414,470	1,943,942	2021 онд "Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/06 дугаар захирамжаар үйл ажиллагааг нь хязгаарлах салбар, чиглэлд биеийн тамир, спортын арга хэмжээ орсонтой холбогдуулан "Мөнгөн Улаанбаатар" өвлийн наадмыг зохион байгуулах боломжгүй болсон. 2019-2024 онд өвлийн биеийн тамир, спортын арга хэмжээнд давхардсан тоогоор 1,943,942 иргэн хамрагдсан.
5	Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэдийн тоо	Сорилд хамрагдсан иргэдийн тоо	165,100	0	0	175,417	175,000	193,000	708,517	2020, 2021 онд "Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/06 дугаар захирамжаар үйл ажиллагааг нь хязгаарлах салбар, чиглэлд биеийн тамир, спортын арга хэмжээ орсонтой холбогдуулан хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах арга хэмжээг зохион байгуулаагүй. 2019-2024 онд бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд давхардсан тоогоор 708,517 иргэн хамрагдсан байна.
6	Багийн спортын төрлөөр зохион байгуулсан уралдаан тэмцээнд оролцсон хүүхэд, багачуудын тоо	Тэмцээн, уралдаанд оролцогчдын тоо /өссөн дүнгээр/	145,800	147,872	0	145,200	145,350	158,746	742,968	МУ-н шадар сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 128, А/433, А/754, А/196 дугаар хамтарсан тушаалаар нийслэлд байршилтай өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн танхимын сургалтыг 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрөөс зайн сургалтад шилжүүлсэнтэй холбогдуулан "Улаанбаатар лиг" сагсан бөмбөг, волейбол, хөлбөмбөгийн тэмцээнүүдийг зохион байгуулах боломжгүй болсон. 2019-2024 онуудад багийн спортын төрлөөр зохион байгуулсан тэмцээнд давхардсан тоогоор 742,968 хүүхэд, багачууд хамрагдсан байна.
7	Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд оролцсон тамирчдын тоо	Тэмцээнд оролцогч тамирчдын тоо /өссөн дүнгээр/	152,096	3496	2839	7888	7967	7888	182,174	2019-2024 онуудад Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд оролцсон тамирчдын тоо
8	Спортын уралдаан тэмцээнд тамирчдын тоо		198,566	153,803	7,086	155,138	190,158	213,896	918,647	2019-2024 онд зохион байгуулсан спортын уралдаан, тэмцээнд оролцсон тамирчдын тоо
9	Хамтарч ажилласан спортын холбоод	Тоо /нэмэгдсэн дүнгээр/	27	16	21	15	24	27	27	2019-2024 онд төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор давхардсан тоогоор хамтран ажилласан спортын холбоод
10	Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн спортын төрлийн тоо	Өсвөрийн шигшээ багуудын спортын төрлийг нэмэгдүүлсэн тоо /өссөн дүнгээр/	22	22	24	24	28	28	28	Өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг бэлтгэх зорилгоор Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийг спортын 28 төрөлд хүүхэд, багачуудыг хамруулж байна.
11	Биеийн тамир, спортын зориулалтаар байгуулагдсан талбай	Тоо /нэмэгдсэн дүнгээр/	99	100	103	105	141	147	147	Биеийн тамир, спортын зориулалтын гадна талбай 147 байгуулагдсан байна.
12	Спортын барилга байгууламжийн хүртээмж	1000 хүнд ноогдох шалны талбай /Мкв/	59	60	61	62	63.5	65	65	Спортын барилга байгууламжийн хүртээмж 65 мкв хүрсэн байна.

